

УЦУОШГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 15 тоот тушаалын 3 дугаар хавсралт



## ТЕХНИКИЙН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Журмын зорилт, хамрах хүрээ

- 1.1 Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа машин техник, тоног төхөөрөмжийн ашиглалтанд хяналт тавих, гарсан эвдрэл гэмтэлд үнэлэлт дүгнэлт өгөх.
- 1.2 Шинжилгээний ажилд ашиглагдаж байгаа болон нөөцөнд байгаа хэмжлийн багаж, автомат төхөөрөмж (станц)-ийн ашиглалтын технологийн мөрдөлтөнд хяналт тавих, гарсан эвдрэл гэмтэлд техникийн дүгнэлт гаргах.
- 1.3 Төв болон орон нутгийн бүх салбар нэгжүүдэд ашиглагдаж байгаа болон нөөцөнд байгаа машин, тоног төхөөрөмж, шинжилгээний ажлын хэмжих хэрэгсэлүүд хамаарна.

### Хоёр. Баримтлах бодлого

2.1 Төв орон нутгийн салбар нэгжүүдэд ашиглагдаж байгаа машин, тоног төхөөрөмжинд гарсан:

- эвдрэл гэмтлийн судалгааг гаргах
- эд ангийн гэмтлийн шинж байдлыг тогтоосон байх
- тухайн эд ангид засвар үйлчилгээ хийж ашиглаж болох эсэхийг тогтоох

2.2 Төв орон нутгийн салбар нэгжүүдэд ашиглагдаж байгаа болон нөөцөнд байгаа хэмжлийн багажинд гарсан:

- Хэмжих хэрэгслийн судалгаа гаргах
- Хэмжих хэрэгслийн гэмтэлийг тодорхойлох
- Гэмтэл гарсан шалтгааныг тодорхойлох
- Шаардлагатай хэмжих хэрэгсэл, автомат төхөөрөмжинд техникийн гэрчилгээ хөтлүүлэх

### Гурав. Комиссын гишүүдийн үүрэг

3.1 Техникийн комиссын гишүүн нь тухайн техник, тоног төхөөрөмжинд гарсан гэмтэл, эвдрэлд зөв үнэлэлт дүгнэлт өгөх

3.2 Хэмжлийн багаж, хэмжих хэрэгсэл, автомат төхөөрөмжинд гарсан гэмтлийг судлаж, шинж байдлыг үнэн зөв тогтоох

3.3 Гэмтэл, эвдрэлд эд анги, хэмжих хэрэгсэлд акт баримт үйлдэх, бүртгэл хөтлөх

### Дөрөв. Хэрэглэх маягт

4.1 Ажил мэргэжлийн онцлогт тохирсон маягтыг хэрэглэж, комиссын гишүүдийн гарын үсгээр баталгаажуулна.

### Тав. Гаргах шийдвэр

5.1 Эвдрэл, гэмтэл гарсан тоног төхөөрөмжийн гэмтлийг тогтоож холбогдох саналаа байгууллагын захиргаанд уламжилна.

5.2 Актлах, солих сэлбэг, хэрэгсэлд дүгнэлт гаргаж акт үйлдэнэ.